



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 15

Хэрлэн сум

Г Банкны баталгаа гаргуулах тухай Г

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.16 дахь заалт, Эрчим хүчний сайдын 2018 оны 07 дугаар сарын 31ны өдрийн а/2768 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах зорилгоор Чойбалсангийн ДЦС-ын 110 кВ-ын ил хуваарилах байгууламжийн өргөтгөл, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 110 кВ-ын ЦДАШ барих барилга угсралтын ажлын гэрээний дагуу хөрөнгийн эх үүсвэрт зориулж урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахыг дэмжсүгэй.

2. Урьдчилгаа төлбөрийн баталгаанд компанийн борлуулалтын орлогыг барьцаалахыг холбогдох хууль журмын дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА